



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр баг, Г.Дэмид жанжин 100-1

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх, яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах;
2. Цус цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн яаралтай тусламж, гамшиг онцгой байдлын үед үзүүлэх яаралтай тусламжийн асуудлыг хариуцан мэргэжил арга зүйгээр ханган, гамшиг онцгой байдлын асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, хяналт тавих;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Цус цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдал, яаралтай, гамшиг эрсдлийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр бодлогыг мөрдлөг болгон ажиллах;</p> <p>2. Цус цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдал, яаралтай, гамшиг эрсдлийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр бодлогыг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах;</p> <p>3. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, яаралтай, гамшиг эрсдлийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах.</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Хэрэгжилтийн хувь.</p> <p>Нэгдсэн бодлого, чиглэлийг хангасан эсэх</p>	<p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p>
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Эмнэлгийн ажилчид, удирдах ажилтан, иргэн хуулийн этгээдэд чиглэсэн үйлчилгээ, мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлэх, лавлагаа, зөвлөмж, мэдээллээр хангах;</p> <p>2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын цус цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдал, яаралтай, гамшиг эрсдлийн үед үзүүлэх тусламж үйлчилгээг хянан шалгах, зааварлах, мэргэжлийн зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;</p>	<p>Иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээний ахиц</p> <p>Дэмжлэгт хяналт тогтмолжсон эсэх</p> <p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p> <p>Г</p>



	<p>3. Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэл, бэлэн байдалд судалгаа, дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;</p> <p>4. Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулахад бусад салбар, холбогдох байгууллага, мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллах;</p> <p>5. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг холбогдох эрх зүйн баримт бичигтэй нийцүүлэн боловсруулж, тухай бүр тодотгож, албаны бие бүрэлдэхүүний бэлэн байдал, сургалт, дадлагажуулалтыг зохион байгуулах;</p> <p>6. Цус цусан бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдал, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын талаар холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн талаар мэдээллийн сан байгуулах, баяжуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>7. Эмнэлгийн яаралтай тусламж, түргэн тусламжинд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг салбарын хэмжээнд авч хэрэгжүүлэх;</p> <p>8. Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;</p> <p>9. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн анхны тусламжийн талаар иргэдэд сургалт хийх арга зүйгээр хангах;</p> <p>10. Эмнэлгийн анхны тусламжийн талаар иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах;</p>	<p>Бэлэн байдал хангагдсан эсэх</p> <p>Эрүүл мэндийн албаны үйл ажиллагаа жигдэрсэн эсэх</p> <p>Мэдээний сан бүрдүүлсэн эсэх.</p> <p>Багаж тоног төхөөрөмжийн хангалтын хувь</p> <p>Мэдлэгийн ахиц.</p> <p>Мэдлэгийн ахиц</p> <p>Мэдлэг хандлагын ахиц</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г, Х</p> <p>Г, Х, Т</p> <p>Г, Х, Т</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;</p> <p>2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</p> <p>3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;</p> <p>4. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх;</p>	<p>Ёс зүйн зөрчил гаргасан эсэх</p> <p>Ашиг сонирхлын зөрчилгүй гаргасан эсэх</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Биелэлтийн хувь</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>

	5. Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь	Г
	6. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь	Г
	7. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийн хувь	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	Анагаах ухаан /0912/		
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - Нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - Шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - Аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - Бүтээлч, санаачлагатай ажиллах; - Бусад. 	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Нээлттэй, шударга байх; - Бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - Зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - Шинэ санал, санаачилгаа, бүтээлч хандлагатай байх; - Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; 	

- Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;
- Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй

Бусад харилцах субъект

- Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар
- Эмнэлгийн ажилчид
- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан
- ЭМЯ-ны ЭТ-ийн хэлтсийн холбогдох мэргэжилтэн
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтан
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: **19 10 30**

Дугаар: **181**

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: **2019.12.26**

Дугаар: **1159**

(тамга/тэмдэг)

ДАРГА

P. Gandymaa

Р.ГАНДИЙМАА

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

-----oOo-----